



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар A/117

Улаанбаатар хот


Г Бодлогын баримт бичгийн шинэчлэн  
батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичгийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөө /2018-2021/-г хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө /2018-2021/-ний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Жендэрийн салбар зөвлөлийн дарга, гишүүдэд болон харьяа агентлаг байгууллагын дарга, захирал наарт тус тус даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 2016 оны А\246 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Хууль зүй, дотоод хэргийн  
сайдын 2018 оны 06. сарын 13-ны  
өдрийн ...

тушаалын нэгдүгээр  
хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ  
АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ХУУЛЬ САХИУЛАХ  
БАЙГУУЛЛАГУУДЫН  
ЖЕНДЭРИЙН НЭГДСЭН БОДЛОГО  
(2018-2021)**

Улаанбаатар хот  
2018 он

**Нэг. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлого боловсруулах хэрэгцээ, шаардлага**

- 1.1 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэхэд хууль сахиулах байгуулагууд нь чухал үүрэгтэй бөгөөд Хууль зүй дотоод хэргийн яам нь салбарынхаа бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээнд жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэхийг зорьж байна. Жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх нь бүх хүрээ, бүх түвшний аливаа төлөвлөсөн үйл ажиллагаа, түүний дотор хууль, тогтоомж, бодлого, хөтөлбөрийн эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай нөлөөлөх байдлыг анхаарч тооцох, тэдний ялгаатай хэрэгцээ болон мэдлэг туршилагыг эн тэнцүү үнэлэх үйл явц бөгөөд жендерийн тэгш байдлыг хангах дэлхий дахинь гол стратеги юм.
- 1.2 Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан 2015 онд амжилттай хэрэгжүүлсэн “Оролцоонд суурилсан жендерийн үнэлгээ”-гээр хууль зүйн салбар нь жендерийн нэгдсэн бодлогоо тодорхойлж, тус бодлогыг хууль сахиулах байгууллагын онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдсан. Үнэлгээний зөвлөмжид Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа байгууллагын бүх түвшинд хүний эрх, жендерийн асуудлаарх нэгдсэн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай бөгөөд жендерийн бодлогыг хэрэгжүүлэхэд удирдах ажилтнуудын дэмжлэг чухал болохыг онцлон тусгасан байна.
- 1.3 “Оролцоонд суурилсан жендерийн үнэлгээ”-ний асуулгын судалгаанд оролцсон албан хаагчдын 76.1 хувь нь байгууллагын стратегийн болон үйл ажиллагааны зорилтуудыг хэрэгжүүлэхэд жендерийн бодлого чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь эмэгтэй, эрэгтэй ажилтан, албан хаагчдын хөгжлийн асуудалтай шууд холбоотой төдийгүй салбарын онцлогт тохируулан хүний нөөцийн бодлогоо оновчтой төлөвлөхөд болон байгууллагын хөгжилд сайн нөлөө үзүүлнэ гэж үзсэн.
- 1.4 Мөн 2015 онд зохион байгуулсан “Хууль сахиулах салбар дахь эмэгтэйчүүдийн оролцо” чуулганд оролцогсод хууль сахиулагч эмэгтэйчүүдийн өмнө тулгарч буй асуудалд анхаарал хандуулахыг хүсч, тус салбарт жендерийн мэдрэмжгүй бодлогын нөлөөгөөр эмэгтэй албан хаагчдын удирдах албан тушаалд дэвшин ажиллах, цол ахих, шагнал урамшуулалд тэгш хамрагдах боломж хязгаарлагдмал байгааг онцлон дурьдсан. Энэ нь эрэгтэйчүүд давамгайлан ажилладаг тус байгууллагын *де факто* ялгаварлан гадуурхалтыг үүсгэж, улмаар тус салбарт эмэгтэйчүүдийг хүлээн зөвшөөрөх явдлыг ямар нэгэн нөхцөл, болзол тавин сулруулах, хязгаарлах боломжийг бүрдүүлж болзошгүйг анхаарах шаардлагатайг харуулж байна.
- 1.5 Тиймээс хуулийг сахиулах үүрэг бүхий байгууллага нь эрэгтэй, эмэгтэй албан хаагчдын эрх тэгш байдлыг хангаж буй эсэхэд анхаарч, албан хаагчдаа шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ялангуяа эмэгтэй албан хаагчдад учирч буй саад бэрхшээл, хүндрэлийг арилгах чиглэлээр идэвхитэй арга хэмжээ авах шаардлагатай байна.
- 1.6 Хууль сахиулах байгууллагын жендерийн нэгдсэн бодлого /Цаашид “Жендерийн нэгдсэн бодлого” гэх./ нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Хууль зүйн салбарын нээлттэй бодлого, хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд байгууллага, нэгжийн зорилго, үйл ажиллагаа, тогтолцоо, бүтэц, хүний болон санхүүгийн нөөцийн хуваарилалтаар дамжин, удирдлагын дэмжлэг, хамт олны хүчин чармайлт, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор хэрэгжинэ.

## **Хоёр. Дэлхий нийтийн чиг хандлага, олон улсын туршлага**

- 2.1 Дэлхий нийтээр тэгш байдлыг энх тайван, аюулгүй байдлын суурь хэмээн үзэж, эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын хоорондын холбоог чухалчлан үзэж байгаа бөгөөд нийгмийн бүх гишүүд боломж, нөөц, үйлчилгээ, хамгааллыг тэгш хүртэж, шийдвэр гаргахад тэгш оролцохын чухлыг онцлох боллоо.
- 2.2 Энх тайван, аюулгүй байдлыг хамгаалах болон хууль сахиулах салбарыг эмэгтэйчүүдэд нээлттэй болгох, тэднийг удирдах, шийдвэр гаргах түвшинд ажиллуулахад чиглэсэн санаачлагууд сүүлийн хориод жилийн турш эрчимтэй өрнөж байна. Тухайлбал, НҮБ-ын Аюулгүйн зөвлөл нь “Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал” 1325 дугаар тогтоолыг 2000 онд баталсан. Энэ тогтоол нь Хууль сахиулах салбар дахь эмэгтэйчүүдийн тоог өсгөх төдийгөөр хязгаарлагдахгүй бөгөөд бүхий л бодлого, хөтөлбөр, шийдвэр, үйл ажиллагаанд жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэхэд чиглэгдсэн. Энэ нь эцсийн дүндээ салбартаа цөөнх болж буй эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн онцлог хэрэгцээг хангах, байгууллага аливаа шийдвэр гаргахдаа эмэгтэйчүүд охидын аюулгүй байдал, эрүүл мэнд, хүний эрхийг хамгаалах, жендерт суурилсан хүчирхийлээс урьдчилан сэргийлэхэд анхаардаг болгоход чиглэж байна.
- 2.3 НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс дээрх тогтоолыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор цогц үйл ажиллагааг тодорхойлсон 2122 дугаар тогтоолыг 2013 онд баталсан. Мөн дээрх 2 тогтоолыг үндэслэн НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны хэлтэсээс Жендерийн стратеги (2014-2018) баталжээ. Уг стратеги нь энхийг сахиулах болон аюулгүй байдлыг хангах ажиллагаатай холбоотой бүхий л бодлого, төлөвлөлтөд жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусган нэвтрүүлэх олон улсын эрх зүйн үндэслэл болж байна.
- 2.4 Түүнчлэн дэлхий дахинд хууль сахиулах байгууллагын талаарх “хүчиний байгууллага” гэх уламжлалт ойлголт өөрчлөгдөж, иргэддээ үйлчилдэг байгууллага болгохоор зорьж байна. “Иргэн төвтэй”, иргэдэд үйлчилдэг хууль сахиулах байгууллагыг бий болгоход эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг, жишээлбэл эмэгтэй офицерууд биеийн хүч бага шаардсан арга барилыг илүүд үздэг, хурцадмал байдлыг зохицуулах болон зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэх, багаар ажиллах чадвар илүү байдгийг олон улсын түвшинд хийгдсэн судалгааны үр дүн харуулжээ. Нөхцөл байдлаас шалтгаалан зарим орны хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага эмэгтэй албан хаагчдыг элсүүлэх, үндсэн чиг үүргээрээ тогтвортой ажиллахыг дэмжих, цол ахих, албан тушаал дэвшихэд нь дэмжлэг үзүүлэх тодорхой стратеги хэрэгжүүлэн эмэгтэй албан хаагчдын эзлэх хувийг нэмэгдүүлж байна.
- 2.5 Эдгээр санаачилга нь нэг талаас оролцоо, нөгөө талаас хамгаалалт гэсэн зэрэгцээ хоёр стратегийн хүрээнд өрнөж байгаа ба эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, тэдний эрхийг баталгаажуулах институцийн чадавхийг бэхжүүлэхэд илүү анхаарч байна. Иймд бид олон улсын түвшинд дэвшүүлж буй дээрх зорилт, өрнөж буй санаачлагуудыг угтан харж, өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан хөгжүүлэх шаардлага тавигдаж байгааг анхаарч, бодлогодоо тусгах хэрэгцээтэй болж байна.

## **Гурав. Жендерийн нэгдсэн бодлогын зорилго**

- 3.1 Жендерийн нэгдсэн бодлогын зорилго нь жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яам болон түүний харьяа хууль сахиулах байгууллагын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт үнэлгээнд нэвтрүүлэх замаар байгууллагын бүх түвшинд жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэхэд оршино.
- 3.2 Жендерийн нэгдсэн бодлогод дэвшүүлсэн зорилтуудын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам болон Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий

газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хууль сахиулах их сургууль, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудын үйл ажиллагаагаа жендерийн мэдрэмжтэй болгох шаталсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### **Дөрөв. Жендерийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа**

Жендерийн нэгдсэн бодлогын хүрээнд дараах үндсэн дөрвөн зорилтыг хэрэгжүүлнэ.

**Зорилт 1.** Хууль зүй, дотоод хэргийн яам болон хууль сахиулах байгууллагын бүх түвшний удирдах ажилтнуудын жендерийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, бодлого төлөвлөлтөндөө жендерийн дүн шинжилгээ хийж, ашиглах чадавхийг дээшлүүлэх.

#### **Хүрэх үр дүн:**

- Хууль зүй, дотоод хэргийн болон харьяа Хууль сахиулах байгууллагын бүх түвшний удирдах ажилтнуудын 50 хувь нь жендерийн шаталсан сургалтанд хамрагдаж, бодлого төлөвлөлтийг жендерийн мэдрэмжтэй хийх чадавхитай болно.
- Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд жендерийн үзүүлэлтүүд нэвтрэсэн байна.

#### **Үйл ажиллагааны үндсэн чиглэл:**

- 4.1 Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа Хууль сахиулах байгууллагын бүх түвшний удирдах ажилтнуудад зориулсан жендерийн сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж, шаталсан сургалт хийх;
- 4.2 Хууль сахиулах байгууллагын нэгжүүдэд “Оролцоонд суурилсан жендерийн үнэлгээ”-ний аргачлалыг нэвтрүүлэх;
- 4.3 Бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөний жендерийн мэдрэмжийг үнэлэх хяналтын хуудас, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан туршиж, салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх.

**Зорилт 2.** Хууль сахиулах байгууллагад ажиллаж байгаа эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш боломж олгосон, жендерийн ялгavarлан гадуурхалт, жендерт суурилсан аливаа хүчирхийллээс ангид ажлын орчин болгох.

#### **Хүрэх үр дүн:**

- Хууль сахиулах байгууллагууд жендерийн ялгavarлан гадуурхал, жендерт суурилсан аливаа хүчирхийллээс сэргийлэх, таслан зогсоох, гомдлыг шийдвэрлэх механизмтай болсон байна.
- Ажлын орчин нөхцөл, хангамжийг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээнд тулгуурлан үнэлэх арга хэрэгсэл, түүнийг ашиглах чадавхи бүрдэнэ.

#### **Үйл ажиллагааны үндсэн чиглэл:**

- 4.4 Хууль сахиулах салбарын хууль тогтоомж, эрх зүйн акт, бодлогын баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилтэнд жендерийн дүн шинжилгээ хийж, холбогдох хууль тогтоомж, гэрээ конвенцид нийцүүлэх;
- 4.5 Байгууллагын өдөр тутмын хөдөлмөрийн харилцаа, ажиллах нөхцлийг зохицуулсан эрх зүйн акт, бодлогын баримт бичгүүдэд жендерийн ялгavarлан гадуурхал, жендерт

суурилсан аливаа хүчирхийллээс сэргийлэх, таслан зогсоох, гомдлыг шийдвэрлэх механизмыг суулгах;

- 4.6 Ажлын орчин нөхцөл, хангамжийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээнд тулгуурлан үнэлэх арга хэрэгсэлийг боловсруулж ашиглах.

**Зорилт 3.** Хууль сахиулах салбарт жендерийн тэгш боломжийг дэмжсэн эрх зүй, бодлогын орчинг бий болгож, эмэгтэйчүүдийн оролцооны чадавхийг дээшлүүлэх.

**Хүрэх үр дүн:**

- Хууль сахиулах байгууллагад ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш боломж олгох, эрхийг нь хамгаалах механизм бүрдсэн байна.

**Үйл ажиллагааны үндсэн чиглэл:**

- 4.7 Хүний нөөцийн жендерийн харьцааг сайжруулах бодлого, арга хэмжээг цогцоор тодорхойлж, үндсэн чиг үүргээр ажиллах эмэгтэйчүүдийн тэгш боломжийг бүх түвшинд баталгаажуулах;
- 4.8 Хууль сахиулах сургуулийн бакалавр болон магистрийн сургалтанд элсэгчдийн хүйсийн харьцаанд квот тогтоож, эмэгтэйчүүдийн элсэлтийн хувийг нэмэгдүүлэх;
- 4.9 Хууль сахиулах байгууллагад ажиллаж байгаа эмэгтэйчүүдийг тэгш оролцоо болон эрх хамгааллын асуудлаар чадавхижуулах.

**Зорилт 4.** Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний чадавхийг дээшлүүлэх.

**Хүрэх үр дүн:**

- Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах үндэсний механизм боловсронгуй болно.
- Жендерт суурилсан хүчирхийлийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах эрх зүйн актыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлд дүн шинжилгээ хийх, шийдэх арга замыг тодорхойлох чадавхи бүрдэнэ.

**Үйл ажиллагааны үндсэн чиглэл:**

- 4.10 Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, шийдвэрт үнэлгээ хийж боловсронгуй болгох;
- 4.11 Жендерт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой шинээр батлагдсан хуулиудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндэсний чадавхийг бүрдүүлэх;
- 4.12 Орон нутгийн захиргааны байгууллагын хуулийн хэлтэс, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр чадавхижуулах.

**Тав. Удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагаа, санхүүжилт**

**Удирдлага зохион байгуулалт:**

- 5.1 Жендерийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Жендерийн салбар зөвлөл удирдан зохион байгуулна. Жендерийн салбар зөвлөлийг Төрийн нарийн бичгийн дарга удирдаж, харьяа байгууллагын удирдлага бүрэлдэхүүнд нь орж ажилана.
- 5.2 Жендерийн салбар зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн дарга нь яамны жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна. Яамны жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь тус бодлогыг салбарын түвшинд хэрэгжүүлэх, уялдуулан зохицуулах үүрэг гүйцэтгэж, харьяа байгууллагын жендерийн асуудал хариуцсан ажилтнуудад арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

- 5.3 Жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор байгууллага тус бүр байгууллагын даргаар удирдуулсан жендэрийн дэд зөвлөл байгуулж, жендэрийн асуудал хариуцсан ажилтан томилон ажиллуулна.
- 5.4 Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа Хууль сахиулах байгууллага тус бүр жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд, төсвийн хамт батлан, тухайн оны 1-р сарын 10-ны дотор Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ.
- 5.5 Жендэрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын жилийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас жил бүр шинэчлэн гаргаж, байгууллагуудад хүргүүлнэ.

#### **Хамтын ажиллагаа:**

- 5.6 Монгол Улсын Ерөнхий сайд удирддаг Жендэрийн үндэсний хороо, түүний ажлын албатай жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулах, чадавхи бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллана.
- 5.7 Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөлтэй жендэрт суурисан хүчирхийлэл, түүнээс үүдсэн гомдлыг хянан шийдвэрлэх асуудлаар хамтран ажиллана.
- 5.8 Салбарын жендэрийн нэгдсэн бодлогын хүрээнд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, жендэрийн тэгш байдлыг хангах олон улсын гэрээ конвенцийг сурталчилах, хүний нөөцийг чадавхижуулах, бодлогын 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр төслүүд хэрэгжүүлнэ.
- 5.9 Иргэний нийгмийн байгууллагын дэмжлэгтэйгээр хууль сахиулах байгууллагын жендэрийн бодлогыг хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэх, жендэрт суурисан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нийгмийн хандлагыг төлөвшүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа болон жендэрийн нэгдсэн бодлогын хэрэгжилтгэй холбоотой зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлнэ.

#### **Санхүүжилт:**

- 5.10 Дээр тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг байгууллага тус бүрийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусган, арга хэмжээний зардлын эх үүсвэрийг зааж өгнө.
- 5.11 Хууль зүй, дотоод хэргийн яамны жендэрийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зардлыг жил бүр тооцон төлөвлөж, батлан төсөвт тусгана.
- 5.12 Төсвөөс гадуур шаардагдах санхүүжилтийг олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр бүрдүүлнэ.

#### **Зургаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хэрэгжилтийн тайлагналт**

#### **Хяналт-шинжилгээ үнэлгээ**

- 6.1 Бодлогын баримт бичигт тусгасан зорилт бүрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ-үнэлгээ хариуцсан нэгж урьдчилан тодорхойлсон байна.
- 6.2 Бодлогын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцын хяналтыг байгууллагын Тамгын газрууд хариуцан гүйцэтгэнэ.
- 6.3 Байгууллагын уг бодлогын хүрээнд гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, түүний үр нөлөөг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ-үнэлгээ хариуцсан нэгж үнэлнэ.
- 6.4 Иргэний нийгмийн байгууллагуудаар тус бодлогын 4-р зорилтын хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ хийлгэнэ.

#### **Тайлагналт**

- 6.5 Хууль зүй, дотоод хэргийн яамны хэлтсүүд болон түүний харьяа байгууллагууд нь жендэрийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийн жил бүрийн тайланг дараах оны 01дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.

- 6.6 Хууль зүй, дотоод хэргийн яамны Жендерийн салбар зөвлөл нь тайланг хэлэлцэж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх шийдвэр гарган, санаачлагатай, үр дүнтэй ажилласан байгууллагыг салбарын хэмжээнд шалгаруулж, сайн туршлагыг бусад байгууллагуудад түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.
- 6.7 Хууль зүй, дотоод хэргийн яам нь Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19.1.9-д заасны дагуу Жендерийн Үндэсний хороонд жил бүрийн 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлдэг Жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайландаа жендерийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг багтаан тайлagnана.

80•83

Хууль зүй, дотоод хэргийн сайдын **онь** **жаралт** –ны  
жедрийн **хөтүүш** шалын хөфдүүрээр хавсралт  
өндөрлүгийн **хөтүүш**

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ХАРЬЯА ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖЕНДЭРИЙН НЭГДСЭН БОДЛОГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2018-2021)

№	Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хэрэгжилтийн үе шат		
		2018 он	2019 он	2020 он
<b>Зорилт 1. Хууль сахиулах байгууллагуудын бүх түвшний удирдах ажилтнуудын жендерийн мэдэг ойлголтыг нэмэгдүүлж, болдого төлөвлөлтөө жандэрийн дун шинжилгээ хийж, ашиглах чадавхийг дээшүүлэх</b>				
Хүрэх Үр дүн:				
-	Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа Хууль сахиулах байгууллагуудын бүх түвшний удирдах ажилтнуудын 50 хувь нь жандэрийн шаталсан сургалтанд хамрагдаж, болдого төлөвлөлтийг жендерийн мэдрэмжтэй хийх чадвхитай болно.			
-	Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны жендерийн нэвтрээрэн байна.			
4.1	Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа Хууль сахиулах байгууллагуудын бүх түвшний удирдах ажилтнуудад зориулсан жендерийн ажилтнуудал зориулсан жендерийн сургалтын хэргэлгэдэхүүн боловсруулж, шаталсан сургалт хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяа Хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтнуудад зориулсан жендерийн нэгдсэн боллогыг танилцуулах уулзваат зохион байгуулах</li> <li>- Удирдах ажилтнуудад зориулсан жендерийн сургалтын хэргэлгэдэхүүн боловсруулж, шаталсан сургалт хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Удирдах ажилтнуудад зориулсан жендерийн шаталсан сургалтын хөтөлбөрийн хөтөлбөрийг боловсруулах</li> <li>- Удирдах ажилтнуудад зориулсан жендерийн сургалтын хэргэлгэдэхүүн боловсруулж, шаталсан сургалт хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Удирдах ажилтны жендерийн эхний шатны сургалтад Хууль зүй, дотоод хэргийн яам болон хууль сахиулах байгууллага нэгийн удирдах ажилтнуудын 50 хувийг хамруулах ХЭДХЯ болон хууль сахиулах байгууллага нэгийн удирдах ажилтнуудын 50 хувийг хамруулах</li> <li>- 2 дахь шатны туршилтын жендерийн сургалтыг сонгосон байгууллага Цагдаагийн Ерөнхий газар, орон нутагт (изгаймарт) туриих,</li> <li>- ХСИС-ын Улирдлагын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд дээр боловсруулсан жендерийн сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх ажлыг зөвшилцэн эхтуулэх</li> </ul>
				<ul style="list-style-type: none"> <li>- Хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтнуудыг жандэрийн шаталсан сургалтанд хамруулах арга замыг</li> </ul>

		тодорхойлон нэгдсэн төлөвлөгөө гарган шийдвэрлэх Удираах албан тушаалтын эхийн шалтны туришлтын жандэрийн сургалтуудыг сонгосон байгууллага (Цагдаагийн өрончийн газар, орон нутагт (нэг аймарт), зохион байгуулах	- Оролцоонд сууриссан жандэрийн үнэлгээг сонгогдсон 2 байгууллагад хийх Үнэлгээний үр дүнг тухайн байгууллагад хэрэгжиж буй дүрэм, журамд тусган хэрэгжүүлэх Оролцоонд сууриссан үнэлгээ танилцуулах сургалтыг хийх 2018-2021 онд оролцоонд сууриссан жандэрийн үнэлгээ хийх байгууллагуудын дарааллыг тодорхойлон төлөвлөгөө гаргах 2018 онд үнэлгээ хийх 2 байгууллагыг сонгон хариуцах настж, мэргэжилтийнг томилон, сургалт хийж бэлтгэлийг хангах	- Хууль сахиулах байгууллагуудын төлөөллийг оролцуулсан оролцоонд сууриссан жандэрийн үнэлгээний аргачалыг танилцуулах сургалтыг хийх 2018-2021 онд оролцоонд сууриссан жандэрийн үнэлгээ хийх байгууллагуудын дарааллыг тодорхойлон төлөвлөгөө гаргах 2018 онд үнэлгээ хийх 2 байгууллагыг сонгон хариуцах настж, мэргэжилтийнг томилон, сургалт хийж бэлтгэлийг хангах	- 2019 онд жандэрийн үнэлгээ хийсэн байгууллагын үнэлгээний мөрөөр хийсэн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлхэх Оролцоонд сууриссан үнэлгээ жандэрийн үнэлгээг сонгогдсон 2 байгууллагад хийх 2020 онд үнэлгээ хийх байгууллагуудад бэлтгээл зохион байгууллагыг хийж, сургалт хийх 2019 онд үнэлгээ хийх 2 байгууллагын бэлтгэл зохион байгууллагыг хийж, сургалт хийх	- 2020 онд жандэрийн үнэлгээ хийсэн байгууллагуудын үнэлгээний мөрөөр хийсэн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлхэх Оролцоонд сууриссан жандэрийн үнэлгээний зарллыг байгууллагуудын төсөвт тусгах, харуулах нэгж, ажилтыг тодорхойлон ажлын байрны тодорхойлолт, ур дунгийн гарээнд тусгах
4.2	Хууль сахиулах байгууллага, нэгжүүдэл “Оролцоонд сууриссан жандэрийн үнэлгээ”-ний аргачалыг нэвтрүүлэх	- Жандэрийн болдлогыг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулан, байгууллагуудад хургуулэх Жандэрийн шалтуур Узүүлэлт, хяналтын хуудсыг байгууллагуудын үндсэн чиг Урэг, үйл ажиллагааны онцлогтогхируулан боловсруулах	- Сонгосон байгууллагын хүний нөөцийн болдлогоо хөтөлбөр, түүний хэрэгжилтэд жандэрийн дун шинжилгээ хийж үр дүнг ХЗДХЯ-ны жандэрийн салбар зөвлөлдөр түүний таницуулах Салбарын болдлогот хүйсээр ангиласан статистик мэдээллийг ашиглах нохцлийг бурдлуулж	- Жандэрийн шалгур Узүүлэлт, хяналтын хуудсыг байгууллагуудад хургуулэх Жандэрийн шалтуур Узүүлэлт, хяналтын хуудсыг байгууллагуудын үндсэн чиг Урэг, үйл ажиллагааны онцлогтогхируулан боловсруулах	- Жандэрийн шалгур Узүүлэлт, хяналтын хуудсыг байгууллагуудад хургуулэх Жандэрийн дун шинжилгээ хийж үр дүнг ХЗДХЯ-ны жандэрийн салбар зөвлөлөөс жандэрийн дунгийн нөөцийн болдлогоо хөтөлбөр, түүний хэрэгжилтийг жандэрийн мэдрэмжтэй болгох чиглэлээр гаргасан удирдамжийг бүх байгууллагад нэвтрүүлэх Удирдамж боловсруулах	
4.3	Бодлого, төлөвлөлт, Үйл ажиллагааны жандэрийн мэдрэмжийг үнэлхэх хяналтын хуудас, шалтуур Үзүүлэлтгүүдийг боловсруулан туршиж, салбарын хяналт-шинжилгээ, Үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх	- Жандэрийн болдлогыг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулан, байгууллагуудад хургуулэх Жандэрийн шалтуур Узүүлэлт, хяналтын хуудсыг байгууллагуудын үндсэн чиг Урэг, үйл ажиллагааны онцлогтогхируулан боловсруулах	- Сонгосон байгууллагын хүний нөөцийн болдлогоо хөтөлбөр, түүний хэрэгжилтэд жандэрийн дун шинжилгээ хийж үр дүнг ХЗДХЯ-ны жандэрийн таницуулах Салбарын болдлогот хүйсээр ангиласан статистик мэдээллийг ашиглах нохцлийг бурдлуулж	- Жандэрийн шалгур Узүүлэлт, хяналтын хуудсыг байгууллагуудад хургуулэх Жандэрийн шалтуур Узүүлэлт, хяналтын хуудсыг байгууллагуудын үндсэн чиг Урэг, үйл ажиллагааны онцлогтогхируулан боловсруулах	- Жандэрийн шалгур Узүүлэлт, хяналтын хуудсыг байгууллагуудад хургуулэх Жандэрийн шалтуур Узүүлэлт, хяналтын хуудсыг байгууллагуудын үндсэн чиг Урэг, үйл ажиллагааны онцлогтогхируулан боловсруулах	

			- Хүйсээр ангилаан мэдээлийн сантай болох	
<b>Зорилт 2. Хууль сахиулах салбарг ажиллаж байгаа эмэгтэй, эрэгтэй хүмүүст тэгш боломж олгосон, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэргүй сууриссан аливаа</b>				
<b>Хүрэх Үр дун:</b>				
- Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль сахиулах байгууллагуудад жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэргүй сууриссан аливаа хүчирхийлээс сэргийлэх, таслан зогсоох, томдлыг шийдвэрлэх механизмтэй болсон байна.				
- Ажлын орчин нөхцөл, хангамжийг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээнд тулгуурлан үнэлэх арга хэрэгслэл бурдэж, ашиглах чадавхи бурдэнэ.				
4.4	Хууль сахиулах салбар дахь хөдөлмөрийн хариулсаны эрх зүй, бодлого, тэдгээрийн хэрэгжилтэнд жендэрийн дүн шинжилгээний эхийг, Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулинд нийтийн тийн албаны тухай болон хөдөлмөрийн захирагчны орон тооны харьцааг үзлж зохистой харьцааг тодорхойлон холбогдох баримт бичгүүдэл тусгах	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагуудын хэмжээнд хэрэгжиж буй дүрэм, журамыг шинжлэн Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулинд нийтийн тийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн хуульд нийцүүлж мөрдүүлэх хянантын тогтолцоог бий болгох</li> <li>- Байгууллагууд дахь үндсэн чиг Ургийн орон тоо болон Үйлчилгээний захирагчны орон тооны харьцааг үзлж зохистой харьцааг тодорхойлон холбогдох баримт бичгүүдэл тусгах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Илүү, уртассан цагаар ажиллах нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажилтан албан хаагчдын ажил - амьдралын тэнцвэрэйг хадгалах зохицуулалтын механизмыг бий болгох</li> <li>- Байгууллагууд дахь үндсэн чиг Ургийн орон тоо болон Үйлчилгээний захирагчны орон тооны харьцааг үзлж зохистой харьцааг тодорхойлон холбогдох баримт бичгүүдэл тусгах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль сахиулах салбар дахь хөдөлмөрийн хариулсаны эрх зүй, бодлого, тэдээрийн хэрэгжилтэнд жендэрийн дүн шинжилгээ хийх Байгууллагын дотоод журмыг төрийн албаны тухай болон хөдөлмөрийн хуульд нийцүүлж мөрдүүлэх хянантын тогтолцоог бий болгох</li> </ul>
4.5	Байгууллагын өдөр тутмын хөдөлмөрийн гадуурхал, ажлын бэлгийн дарамтын асуудлаар бүх байгууллагын ажилтуулалтад мэдээлэл хүргэх эрх зүй, боллогын баримт бичгүүдэд жендэрийн ялгаварлан гадуурхал, жендэргүй сууриссан аливаа хүчирхийлээс Сэргийлэх, таслан зогсоох, томдлыг шийдвэрлэх механизмыг суулгах	<ul style="list-style-type: none"> <li>- Жендерийн ялгаварлан гадуурхал, ажлын бэлгийн дарамтын асуудлаар бүх байгууллагын ажилтуулалтад мэдээлэл хүргэх эрх зүй, боллогын баримт бичгүүдэд жендэрийн ялгаварлан гадуурхал, жендэргүй сууриссан аливаа хүчирхийлээс Сэргийлэх, таслан зогсоох, томдлыг шийдвэрлэх механизмыг суулгах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Жендерийг сууриссан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас сэргийлэх, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрэх арга зам, түүний хэрэгжилтийг үзэж, хариулан туришлага солицож сайджруулах семинаар хэзэлцүүлэг хийх</li> <li>- Семинаар хэзэлцүүлгийн үр дүнд удирдах ажилтын зөвлөгөөнд танилцуулж шийдвэрүүлэх</li> </ul>	
4.6	Ажлын орчин нөхцөл, хангамжийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдал, шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын орчин нөхцөл, хангамжийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдал, шийдвэрлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын орчин нөхцөл, хангамжийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдал, шийдвэрлэх</li> <li>- Судалгаанд үнлэслэн ажиллах орчин нөхцөл хангамжийг</li> </ul>	

<p>онцлог хэрэгцээнд түлпүүрлан үнэлэх арга хэрэгслийг боловсруулан туршиж, түүнийтээ ашиглан үнэлтэй хийх</p> <p><b>Хүрэх үр дүн:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хууль сахиулах байгууллагад ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдэд төгш боломж олгох, эрхийг нь хамгаалах механизм бурдсан байна.</li> <li>- Хууль сахиулах байгууллагуудад үндсэн чиг үргээр ажиллах эмэгтэйчүүдийн зэлэх хувь 1.2 дахин нэмэгдэнэ.</li> </ul>	<p>онцлог хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг ажилтнуудын оролцоотой үнэлэх асуулга, хяналтын хуудас боловсруулан турших. Үндл дараах асуудлыг багтаасан байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хувцас хэрэглэл,</li> <li>- Тоног төхөөрөмж,</li> <li>- Ариун цэврийн болон хувцас солих, усанд орх, амрах, хүхэд хөхүүлэх өрөө</li> <li>- Ажлын үргэлжлэх болон завсарлах цаг</li> <li>- Ажилд ирж очих тээвэр</li> <li>- Эрүүл мэндийн үзэг үйтгилгээ</li> </ul>	<p>онцлог хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг ажилтнуудын бүр үнэлтэй хийх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн үзэг үйтгэлийг эрэгтэй ажилтнуудад илэрсэн түүсмэл овдюүлүүдийг ажлын онцлог, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн зэрэглэлд оруулах асуудлыг судлан шийдвэрлэх</li> <li>- Ажлын үргэлжлэх болон завсарлах цаг</li> <li>- Ажилд ирж очих тээвэр</li> <li>- Эрүүл мэндийн үзэг үйтгилгээ</li> </ul> <p><b>Зорилт 3. Хууль сахиулах салбарт жендерийн тэгш боломжийг дэмжсэн эрх зүй, болдогын орчинг бий болгож, эмэгтэйчүүдийн оролцооны чадавхийг дээшилүүлэх</b></p> <p><b>Хүрэх үр дүн:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хууль сахиулах байгууллагад ажиллаж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдэд төгш боломж олгох, эрхийг нь хамгаалах механизм бурдсан байна.</li> <li>- Хууль сахиулах байгууллагуудад үндсэн чиг үргээр ажиллах эмэгтэйчүүдийн зэлэх хувь 1.2 дахин нэмэгдэнэ.</li> </ul> <p><b>4.7 Хүний нөөцийн жендерийн харьцааг сайжруулах болдого, арга хэмжээг цогцоор тодорхойлж, бүх түвшний үндсэн чиг үргэнийн хүрээнд ажиллах эмэгтэйчүүдийн тэгш боломжийг хэрэглэж, боловсруулан нэгтгэх цуглуулсан эштэй</b></p>
----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

			баталгаажуулсан зохицуулалтыг хийх
4.8	Хууль сахиулах сургуулийн бакалавр болон магистрийн сургалтанд элсэгчдийн хүйсийн харыаанд квот тогтоож, Эмэгтэйчүүдийн элсэлтийн хувийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Эрх зүйн шинэчлэлийн хурээнд шинээр гарч ирж буй чиг Уүрэгтэй холбоотой мэргэшсэн анги нээж эмэгтэй хүн элсүүлэх боломжийг судлах</li> <li>- Эмэгтэй хүн ажиллах боломжтой гэж тодорхойлсон ажлын байруудал ажиллах элсэлтэнд эмэгтэйчүүдийн квот заах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ХСИС-ын бакалавр, магистрын элсэлтийн шалгуурыг женэдрийн өнцгөөс Үнэлж, шууд бусаар ялгаварлан гадуурсан заалтуудыг хасах</li> <li>- Эмэгтэй хүн ажиллах боломжтой гэж тодорхойлсон ажлын байруудал ажиллах боловсон хүчиний сургалтуудын элсэлтэнд эмэгтэйчүүдийн квот заах</li> </ul>
4.9	Хууль сахиулах байгууллагад жендерийн тэгш байдлыг хангах тогтолцоог бий болгож, Эмэгтэйчүүдийг чадавхижуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль сахиулах байгууллага тус бүр жендерийн асуудлаар дэл зөвлөл байгуулах, зөвлөлийн ажиллах журмыг батлах, Үйл ажиллагааны зардлыг байгууллагын төсөвт суулах</li> <li>- Жендерийн асуудал хариуцсан ажилтанг томилох, урамшуулалт олтох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хууль сахиулах салбарын эмэгтэйчүүдийн оролцоо сэдвэet хурлыг жил бүр зохион байгуулах ажлыг эхлүүлэх</li> <li>- Гадаад улс орнуудын хууль сахиулах байгууллагууд даахь эмэгтэйчүүдийн Эрхийг хамгаалах тогтолцооны туршилагыг судлан тунцлэлийг Үүсгэн хөгжүүлэх</li> </ul>
4.10	Хуандарт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний чадавхийг дээшүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хүчин тогтолцдээр үйлчилж буй хууль тоогоомжид жендерийн дун шинжилгээ хийх судалгааны баатай байгуулсан сургалт хийх Хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн барихын эмнэ жендерийн үнэлгээ хийх шалгугур үзүүлэлтүүдийг боловсруулан мөрдүүлэх</li> <li>- Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хүчин тогтолцдээр үйлчилж буй хууль тоогоомжид жендерийн дун шинжилгээ хийх шийдвэрт үнэлгээ хийх Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тунтэй тэмцэх эрх зүйн орчинд хонлогдох өөрчлөлтүүдийг оруулан мөрдүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагуудын дотоод болон гадаад улс орнуудад болох сургалтанд Үндсэн чиг Уүргийн эмэгтэй ажиллагаанд эмэгтэй албан хагачын ороцоог нэмэгдүүлэх хөгжүүлэх</li> <li>- Хууль сахиулах сургалтуудыг чадавхижуулах</li> <li>- Гадаад улс орнуудын хууль сахиулах байгууллагууд даахь эмэгтэйчүүдийн Эрхийг хамгаалах тогтолцооны туршилагыг судлан тунцлэлийг Үүсгэн хөгжүүлэх</li> <li>- Хууль сахиулах салбарын эмэгтэйчүүдийн оролцоо сэдвэet хурлыг жил бүр зохион байгуулах ажлыг эхлүүлэх</li> <li>- Гадаад улс орнуудын хууль сахиулах байгууллагууд даахь эмэгтэйчүүдийн Эрхийг хамгаалах тогтолцооны туршилагыг судлан тунцлэлийг Үүсгэн хөгжүүлэх</li> <li>- Хууль сахиулах салбарын эмэгтэйчүүдийн оролцоо сэдвэet хурлыг жил бүр зохион байгуулах ажлыг эхлүүлэх</li> <li>- Гадаад улс орнуудын хууль сахиулах байгууллагууд даахь эмэгтэйчүүдийн Эрхийг хамгаалах тогтолцооны туршилагыг судлан тунцлэлийг Үүсгэн хөгжүүлэх</li> <li>- Жэндэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хүчин тогтолцдээр үйлчилж буй хууль тоогоомж, шийдвэрт үнэлгээ хийх Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тунтэй тэмцэх эрх зүйн орчинд хонлогдох өөрчлөлтүүдийг оруулан мөрдүүлэх</li> <li>- Салбарын эрдэм шинжилгээний хүрүүлэдэг багасгахад</li> </ul>

**Зорилт 4. Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний чадавхийг дээшүүлэх**

- Хүрэх Үр дүн:**
- Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний чадавхийг дээшүүлэх
  - Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, таслах зогсоох, хохирогчийг хамгаалах Үндэсний механизм боловсронгуй болно.
- Хийж, шийдэх арга замыг тодорхойлох чадавхи бурдэнэ.**
- |      |                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 4.10 | Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хүчин тогтолцдээр үйлчилж буй хууль тоогоомжид жендерийн дун шинжилгээ хийх судалгааны баатай байгуулсан сургалт хийх Хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн барихын эмнэ жендерийн үнэлгээ хийх шалгугур үзүүлэлтүүдийг боловсруулан мөрдүүлэх | <ul style="list-style-type: none"> <li>- Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хүчин тогтолцдээр үйлчилж буй хууль тоогоомжид жендерийн дун шинжилгээ хийх судалгааны баатай байгуулсан сургалт хийх Хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн барихын эмнэ жендерийн үнэлгээ хийх шалгугур үзүүлэлтүүдийг боловсруулан мөрдүүлэх</li> <li>- Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тунтэй тэмцэх эрх зүйн орчинд хонлогдох өөрчлөлтүүдийг оруулан мөрдүүлэх</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн нэгдсэн болдогын хүрээнд төрийн захирагааны төв байгууллагуудын хуулийн хэлсүүд тухайн салбарын хууль тогтоомжийн жендерт суурilsan хүчирхийлэлтэй холбоотой тунтэй тэмцэх эрх зүйн орчинд хонлогдох өөрчлөлтүүдийг оруулан мөрдүүлэх</li> <li>- Салбарын эрдэм шинжилгээний хүрүүлэдэг багасгахад</li> </ul> |
|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

		<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн нэгдсэн боллогын хүрээнд төрийн захирагааны төв байгуулагаудын хуулийн хэлтсүүдийн жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чадавхийг дээшпүүлэх сургалтууд хийх</li> <li>- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоогийн шинээр баглагдсан хуулиульг харгжүүлээд шардлагатай дүрэм, журам, зааврыг батлан хэргэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй ялгарварлан гадуурхлыг арилгах асуудлаар илтгэл оруулах</li> <li>- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоогийн шинээр баглагдсан хуулиульг харгжүүлээд шардлагатай дүрэм, журам, зааврыг батлан хэргэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжилтнийг томилж, ажлын байрны тодорхойлонтонд нь оруулах</li> <li>- Салбарын эрдэм шинжилгээний хурлуудын агуулгад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, ялгаварлан гадуурхлыг арилгах сэdvээр жил бур илтгэл оруулах зохицуулалт хийх</li> </ul>
4.11	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоогийн шинээр баглагдсан хуулиудыг хэргэгжүүлээд шаардлагатай үндэсний чадавхийг бурдтуулэх	<ul style="list-style-type: none"> <li>- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоогийн шинээр баглагдсан хуулиудыг хэрэгжүүлээд шаарддаахаа мэдлэг үр чадвар олгох агуулыг байгууллагудад хийгдэж буй сургалтуудын агуулга, хөгөөбөрт тусгах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Клиник сургалтыг жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн ирээний нийгмийн байгууллагуудын зочин багши наратай хамтран ХСИС дээр зохион байгуулах</li> <li>- Жендэрт суурилсан хүчирхийлэл, тэрдундаа гар булийн хүчирхийлэлтэй тэмцэх хугацаат теслийг хэргэгжүүлэх замаар хууль сахиулах байгуулагуудын чадавхийг бэхжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ХСИС-ын бүх шатны сургалтанд клиник сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх</li> <li>- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үр дүнтэй хамтын ажиллагааг дэмжсэн үндэсний хөтөлбөрий - баглак</li> </ul>
4.12	Орон нутгийн хуулийн хэлтэс, гэмт хэргээс үрдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, ЖЭТБХТ хуулийг хэргэгжүүлээд хууль сахиулах байгууллагуудын орон нутаг дахь манайлын нутгийн нийгмийн хөгжлийн боллогод тусгах чадавхи хэргэгжүүлэх удирдамж боловсруулан хүргүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- ХЭДХ-ийн сайд нийслэл, аймгуудын засаг дарга наартай байгуулах ҮР ДУНГИЙН гэрээний агуулгад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, ЖЭТБХТ хуулийг хэргэгжүүлэх талаар заалт оруулж, уг заалтыг хэргэгжүүлэх чадавхийг чиглэлээр чадавхижуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэл, аймгуудын хууль зүйн хэлтэс, гэмт хэргээс үрдчилан сэргийлэх зөвлөлийн гишүүдэд жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, уг асуудлыг орон нутгийн чадавхийг бэхжүүлэх чиглэсэн туршилтын төслийг 3 аймаг, нэг дүүрэгт хэргэгжүүлэх</li> <li>- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, ЖЭТБХТ хуулийг хэргэгжүүлээд хууль сахиулах байгууллагуудын орон нутаг дахь манайлын чадавхийг бэхжүүлэх чиглэсэн туршилтын төслийг 3 аймаг, нэг дүүрэгт хэргэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, ЖЭТБХТ хуулийг хэргэгжүүлээд хууль сахиулах байгууллагуудын орон нутаг дахь манайлын чадавхийг бэхжүүлэх чиглэсэн туршилтын төслийн сайн туршилтыг улс дахар гүзэн дэлгэрүүлэх</li> </ul>